-

# ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| Худалдан авах ажиллагааг төлөвлөх, батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах, худалдан авах ажиллагааны тогтолцоонд техник технологи, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд хүний оролцоог багасгасан үйл ажиллагаа дэмжин ажиллах, Орон нутгийн өмчийн талаар бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, өмчийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлээр хяналт тавих | | | | | | | |
| **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулна.** | - | Хөрөнгийн ашиглалт | 80 | 90 | 2023 жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчийн 22 байгууллагын 28 ашиглалтгүй барилга байгууламжийг ашиглах зорилгоор 177 иргэн, хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулан, түрээсээр эзэмшүүлэн, түрээсийн орлогын төвлөрүүлэлтэд хяналт тавьж, орлогын 30 хувийг орон нутгийн түрээсийн орлогын 100080000953 тоот дансанд төвлөрүүлэн ажиллалаа. 2023 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 43 тогтоол гарч үүнээс 24 байгууллагын 527.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий 31 тээврийн хэрэгсэл, 1 барилга байгууламжийг дуудлагаар худалдах, 5 байгууллагын 127.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 13 ширхэг байгууламжийг актлах, нийт 587.2 сая төгрөгийн балансын үнэ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүхий 909 ширхэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг акталж данснаас хасах, 4 байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 32.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг актлах, 3 байгууллагын 229.7 сая төгрөгийн үнэ бүхий шугам сүлжээ, 126.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх, 214.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 айлын 5 орон сууцыг хувьчлах, 4 байгууллагын 82.2 сая төгрөгийн балансын үнэтэй 4 тээврийн хэрэгслийг хэрэгцээт байгууллагад шилжүүлэх, 4 байгууллагын 15 ширхэг илүүдэлтэй ашиглахгүй байгаа тоног төхөөрөмжийг дутагдалтай байгаа байгууллагад балансаас балансад шилжүүлэх шийдвэр гаргуулан тогтоолын биелэлтэд хяналт тавин ажиллалаа. 2022 оны эд хөрөнгийн улсын үзлэг тооллогоор илэрсэн ашиглалтгүй 9,7 тэрбум төгрөгийн 1851 ширхэг хөрөнгө байснаас 170,5 сая төгрөгийн 14 ширхэг хөрөнгийг засаж, сэлбэн ашиглалтад оруулан ашиглаж, ашиглах боломжгүй болсон 8,2 тэрбум төгрөгийн 1705 ширхэг хөрөнгийг акталж, данснаас хассан. Хөрөнгийн ашиглалт 93 хувь. | |
| 1.1 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт тавих | - | Тухайн жилд хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тоо | 141 | 142 | Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр баталсан “Орон нутгийн өмчит байгууллагуудын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, худалдан авах ажиллагааны зохион байгуулалтад хийгдэх хяналт, шалгалтын удирдамж”-ын дагуу орон нутгийн өмчит 135 байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт шалгалт хийж, цаашид анхаарах | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асуудлаар зөвлөмж өгч ажиллалаа. Хяналт шалгалтын хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогоор илэрсэн зөрчил, дутагдлыг шийдвэрлэсэн байдал, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, агуулахын эмх цэгц, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэл, сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагаа, ажлын тайлан, орон нутгийн өмчийг түрээсийн журмын дагуу түрээслүүлж буй байдал, тогтоолын биелэлт, түүний хэрэгжилтийг заасан хугацаанд ирүүлдэг байдал зэрэгт хяналт тавьж, зарим байгууллагуудад эд хөрөнгийн түүвэрчилсэн тооллогыг хийж, хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд 13 байгууллагын ашиглалтгүй байгаа 17 ширхэг тээврийн хэрэгсэл, 11 байгууллагын 19 ширхэг барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах, актлах, дуудлагаар худалдах саналаа, АИТХ-ын 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн дагуу материалын бүрдлийг хангаж ирүүлэх талаар зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн дагуу 4 байгууллагын 7 ширхэг тээврийн хэрэгсэл, 2 байгууллагын 9 ширхэг барилга байгууламжийн актлах, дуудлагаар худалдах санал, материалын хамт ирснийг АИТХурлаар хэлэлцүүлэн батлууллаа. Хулд сумын Ерөнхий ЕБС-ийн ашиглалтгүй байсан 50 хүүхдийн дотуур байрын барилгыг төрийн албан хаагчдын орон сууц болгох зөвлөмж өгснийг Хулд сумын ЗДТГ дэмжин засварын зардлын төсвийг батлууллаа. Мөн 14 сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 292 гишүүдэд Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам, эд хөрөнгийн эзэмшилт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалт, хадгалалт, хамгаалалт, анхаарах асуудлуудын талаар чадавхжуулах сургалт зохион байгууллаа. | |
| 1.2 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй байгаа хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд оруулан ашиглалтыг сайжруулах | - | Орлого төвлөрүүлэх хувь | 95 | 97 | Орон нутгийн өмчит 22 хуулийн этгээдийн 177 иргэн хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулан, түрээсийн орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж ажиллалаа. 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар орон нутгийн түрээсийн орлогын 100080000953 тоот дансанд 24.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлээд байгаа бөгөөд түрээсийн орлогын төвлөрүүлэлт 95 хувьтай байна. Мөн орон нутгийн өмчит 20 байгууллагын 21 тээврийн хэрэгсэл, 2 байгууллагын 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд нийт 188.8 сая төгрөгийн орлого төвлөрүүллээ. Акталсан хөрөнгө, барилга, их засвараас гарсан материалыг худалдан борлуулахад хяналт тавьж, орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд 693.5 мянган төгрөг төвлөрүүлсэн. 2023 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар орон нутгийн орлогын дансанд нийт 189.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, орлогын төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ. | 100 |
| 1.3 | Улсын болон орон нутгийн төсөв, гадаад дотоодын зээл, тусламж хандив болон бусад эх үүсвэрээр хийгдсэн үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэх | - | Үндсэн хөрөнгийг бүртгэсэн хувь | 95 | 100 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан 2,2 тэрбум төгрөгийн өртөгтэй Эрдэнэдалай сумын соёлын төвийн барилга, 4,5 тэрбум төгрөгийн өртөгтэй Сайхан-Овоо сумын 320 хүний суудалтай спорт заал, сургуулийн барилга, 1,2 тэрбум төгрөгийн өртөгтэй Хулд сумын Эрүүл мэндийн төвийн барилга, 1 тэрбум төгрөгийн өртөгтэй Гурвансайхан сумын Ерөнхий боловсролын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн дотуур байрны барилга, 10,5 сая төгрөгийн өртөгтэй Гурвансайхан сумын ЗДТГ-ын барилгын гадна холбооны шугам, Өндөршил сумын ЗДТГ-т хандивын хүрээнд бий болсон 37 сая төгрөгийн өртөгтэй халуун усны барилгыг тус 6 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх тогтоолыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан, тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна. 2023 онд улсын болон орон нутгийн төсөв, төсөл, хөтөлбөр, хандив тусламжаар бий болсон 3.6 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчит 67 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхэд хяналт тавьж ажиллалаа. Хөрөнгийн бүртгэл 100%. | |
| 1.4 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны хөрөнгийн тайланг хүлээн авах, улсын нэгтгэлд хамруулах | - | Тайлан хүлээлгэн өгөх байгууллагын тоо | 142 | 142 | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын мэдээ тайлан хүлээн авах, нэгдсэн цугларалт, сургалт зохион байгуулах тухай 2023 оны А-1/ 516 тоот албан бичгийн дагуу Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2022 оны үндсэн хөрөнгийн тайланг нийт 142 байгууллагаас хүлээн авч, 123.5 тэрбум төгрөгийн балансийн үнэтэй барилга, байгууламж, 27.4 тэрбум төгрөгийн балансын үнэтэй машин тоног төхөөрөмж, 8.6 тэрбум төгрөгийн балансын үнэтэй тээврийн хэрэгсэл, 7.7 тэрбум төгрөгийн балансын үнэтэй тавилга, эд хогшил, 694.5 сая төгрөгийн балансын үнэтэй ном, 934.2 сая төгрөгийн балансын үнэтэй түүх соёлын дурсгалт зүйлс, 2.2 тэрбум төгрөгийн балансын үнэтэй дуусаагүй барилга, 2.1 тэрбум төгрөгийн балансын үнэтэй бусад үндсэн хөрөнгө, 29.9 тэрбум төгрөгийн балансын үнэтэй биет бус хөрөнгийг санхүүгийн тайлан баланстай тулгалт хийж, нэгтгэн, 2023 оны 04 сарын 24-28-ны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрүүдэд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүлээлгэн өгч, улсын тайлан мэдээнд амжилттай нэгтгүүллээ. | |
| 1.5 | Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн харилцааг хууль, журмын дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар шийдвэрлүүлэх | - | Тухайн жилд гарсан тогтоолын хэрэгжилтийн хувь | 100 | 100 | 2023 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар орон нутгийн өмчийн харилцаатай холбоотой нийт 43 тогтоол гарч үүнээс 24 байгууллагын 527.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий 31 тээврийн хэрэгсэл, 1 барилга байгууламжийг дуудлагаар худалдах, 5 байгууллагын 127.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 13 ширхэг байгууламжийг актлах, нийт 587.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 909 ширхэг ашиглалтын шаардлага хангахгүй болсон машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг акталж данснаас хасах, 4 байгууллагын ашиглалтын шаардлага хангахгүй болсон 32.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг актлах, нийт 3 байгууллагын 229.7 сая төгрөгийн үнэ бүхий шугам сүлжээ, 126.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг төрийн өмчид шилжүүлэх, 214.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 4 айлын 5 орон сууцыг хувьчлах, 4 байгууллагын 82.2 сая төгрөгийн балансын үнэтэй 4 тээврийн хэрэгслийг хэрэгцээт байгууллагад шилжүүлэх, 4 байгууллагын 15 ширхэг илүүдэлтэй ашиглахгүй байгаа тоног төхөөрөмжийг дутагдалтай байгууллагад балансаас балансад шилжүүлэх, нийт 9.0 тэрбум төгрөгийн барилга байгууламжийг 7 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх тогтоолуудыг тус тус батлуулан, тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | **Зорилт 2. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй болгож, худалдан авах ажиллагааны гүйцэтгэгч орон нутгийн аж ахуйн нэгжийн эзлэх хувь 2021 онд 34 байсныг 2022 онд 36 хувьд хүргэнэ.** | - | Орон нутгийн ААН-ийн эзлэх хувь | 34 | 36 | 2023 онд улсын болон болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт 19,2 тэрбум төгрөгийн 72 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн үүнээс шууд худалдан авалтын 10 төсөл арга хэмжээ, “Дэрэн сумын цэцэрлэгийн пасадны засвар”, “Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засвар”, “Сайнцагаан сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын авто машин” гэсэн 3 төсөл арга хэмжээг Эрдэнэдалай, Дэрэн, Сайнцагаан сумдын засаг дарга нарт эрх шилжүүлсэн байна. Босго үнээс давсан, тендер шалгаруулалт зохион байгуулах 59 төсөл арга хэмжээнээс 56 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулж 17 тендерт орон нутгийн компани оролцсоноос 9 нь шалгарч гэрээ байгуулсан байна. Энэ нь нийт оролцсон тендерийнхээ 52,9 хувийг эзлэж байна. | 100 |
| 2.1 | Зарлагдсан тендерийн урилга, үр дүнгийн мэдээллийг аймгийн вэбсайт болон пейж хуудсаар тухай бүр мэдээлэх | 1,1 сая | Нийт зарлагдсан тендерээс вэбсайт болон пейж хуудсанд урилга, үр дүнг нийтэлсэн тендерийн эзлэх хувь | 100 | 100 | 2023 оны 12 сарын байдлаар манай газраас зарласан 56 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж урилга болон үр дүнг tender.gov.mn, dundgovi.gov.mn, газрын фейсбүүк хуудсаар тухай бүр олон нийтэд хүргэн ажилласан байна. Нээлттэй тендер шалгаруулалтаар зарлагдсан 35 тендерийн урилгыг “Монголын мэдээ”, “Зууны мэдээ” сонингуудаар ил тод нээлттэй нийтлүүлж 1,187,000 төгрөг зарцуулаад байна. https://user.tender.gov.mn/mn/plan/index?year=2023&selGovernorId=142&selClientId=1483427090499&get=1 | 100 |
| 2.2 | Орон нутгийн төрийн байгууллага, аж ахуйн нэгжид холбогдох хууль, дүрэм журам, цахим | - | Тухайн жилд зохион | 1 | 1 | “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах “ тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын их хурлын чуулганы 2023 оны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системийн ашиглалтын мэдлэг олгох, чадавхжуулах сургалт зохион байгуулах | | байгуулсан сургалтын тоо | | | зургаадугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан бөгөөд тухайн хууль 12 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан. Тус ажлын хүрээнд Сангийн яамтай хамтран хуулийн шинэчилсэн найруулгаар орон нутгийн төрийн байгууллага болон аж ахуйн нэгжийн 30 иргэнд сургалтыг зохион байгууллаа. | |
| 2.3 | Тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт батлуулах, төлөвлөгөөг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, худалдан авах ажиллагааны цахим системд нийтлэх | - | Жагсаалт батлагдаж, хүргүүлсэн хугацаа, нийтэлсэн байдал /тийм-1, үгүй-0/ | 1 | 1 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын 2022 оны 12 сарын 05-ны 64 дүгээр тогтоол, 2023 оны 03 сарын 20-ны 01 дүгээр тогтоол, 06 сарын 27-ны 25 дугаар тогтоолын дагуу төлөвлөн гаргаж аймгийн Засаг даргаар батлуулсны дараа цахим систем tender.gov.mn –д тухай бүр нь шинэчилж Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яамаар батлуулж ажиллалаа. https://user.tender.gov.mn/mn/plan/index?year=2023&selGovernorId=142&selClientId=1483427090499&get=1 | 100 |
| 2.4 | Улсын болон орон нутгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хуульд нийцүүлэн шуурхай зохион байгуулах | - | Тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээний тоо | 2022 онд 75 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. | 40 Төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | 2023 онд Орон нутгийн өмчийн газар нь улсын болон болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт 19.2 тэрбум төгрөгийн 72 бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн бөгөөд үнээс шууд худалдан авалтын 10 төсөл арга хэмжээ, “Дэрэн сумын цэцэрлэгийн пасадны засвар”, “Эрдэнэдалай сумын хүүхдийн ордны засвар”, “Сайнцагаан сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын авто машин” гэсэн 3 төсөл арга хэмжээг Эрдэнэдалай, Дэрэн, Сайнцагаан сумдын засаг дарга нарт эрх шилжүүлсэн байна. Тендер шалгаруулалт зохион байгуулах 59 төсөл арга хэмжээнээс “Гүний худаг гаргах”, “Хот хөдөөгийн сэргэлийн бодлогын хүрээнд хэрэгжих "Нээлттэй аймаг" хөтөлбөр хэрэгжүүлэх, ТЭЗҮ боловсруулах”, “Зураг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөв, ТЭЗҮ боловсруулах” гэсэн ажлуудын зураг төсөв болон ажлын даалгавар ирээгүй учраас зарлаагүй байна. Зураг төсөв, техникийн үзүүлэлт, ажлын даалгавар ирүүлсэн 56 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулаад байна.Энэ онд тендер шалгаруулатаар орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн төсөвт 464 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. https://user.tender.gov.mn/mn/result/?year=2023&selGovernorId=142&selClientId=1483427090499&tenderCode=undefined&get=1 | |
| 2.5 | Төрийн худалдан авах ажиллагаанд үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулах | 4 сая | А3 сертификаттай иргэдийн нөөц нэмэгдүүлэх сургалтын тоо | 2 | 1 | 2023 онд Худалдан авах ажиллагааны /А3/ сертифкаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтыг 2023 оны 06 дугаа сарын 16,17,18 -ны өдрүүдэд "Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв" төрийн бус байгууллагатай хамтран 30 иргэн, 11 дүгээр сарын 07, 08 өдрүүдэд Тогтвортой амжиргаа -3 төсөлтэй хамтран 70 иргэнийг хамруулан зохион байгууллаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар Худалдан авах ажиллагааны /А3/ сертифкаттай иргэдийн нөөц бүрдүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж 90 иргэн тэнцсэн байна. | 100 |
| | | | А3 сертификат эзэмшигч иргэдийн тоо | 256 | 300 | Худалдан авах ажиллагааны /А3/ сертифкаттай А3 сертификат эзэмшигчийн иргэдийн тоо аймгийн хэмжээнд 346 иргэн байна. | |
| 3 | **Зорилт 3. Байгууллагын соёлыг нэвтрүүлэх, удирдах удирдуулах, зарчимд суурилсан иргэдэд ээлтэй, ил тод** | - | Ажил зохион байгуулсан байх | 0 | 1 | Байгууллагын соёлыг нэвтрүүлэх ажлын байрны 5S зармчыг хэрэгжүүлж сар бүрийг аян болгон зарлан ажллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **авлигагүй, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх.** | | Тийм -1 Үгүй- 0 | | | | |
| 3.1 | Ажлын байрны соёл буюу 5S зарчимыг хэрэгжүүлэх. | - | 5S зарчим хэрэгжүүлсэн байх хувиар | 0 | 100 | Ажлын байрны соёл буюу 5S зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 03 сарыг “Сайн ангилан ялгах сар”, 4 сарыг “Сайтар цэгцлэн зохион байгуулах сар”, 5 сарыг “Цэвэрлэж цэмцийлгэх сар”, 6 сарыг “Стандартчилан хэвшүүлэх сар” болгон зарлаад байна. | 100 |
| 3.2 | Ажлын байрны соёл буюу “5S зарчимыг хэрэгжүүлэх“ сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгуулах | - | Сургалтад хамрадгдсан албан хаагчдын тоо | 0 | 7 | Газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Сайхантуяа 2023 оны 03 сарын 01-ний өдөр “Ажлын байрны соёл буюу 5S зарчмыг хэрэгжүүлэх” сургалтыг байгууллагын албан хаагчдад зохион байгууллаа. | 100 |
| 3.3 | Нээлттэй дуудлага худалдааны зар болон үр дүнг иргэдэд ил тод нээлттэй хүргэж ажиллах. | 440 мянга | Ил тод хүргэсэн мэдээллийн байдал хувь | 0 | 100 | Нээлттэй дуудлага худалдааны зарыг иргэдэд ил тод нээлттэй хүргэх ажлын хүрээнд өдөр тутмын хэвлэл болох “Монголын мэдээ”, “Зууны мэдээ”, “Дундговийн амьдрал” сонинд тавьж, байгууллагын фейж хуудасаар тус тус хүргээд байна. Жилийн эцсийн байдлаар дуудлага худалдааны 11 зарыг нийтлүүлж 440,000 төгрөгийг зарцуулаад байна. | 100 |
| 3.4 | Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр, санхүүжүүлэгч байгуулагад төсөл бичиж хүргүүлэх. | - | Төсөл бичиж хүргүүлсэн тоо | 0 | 1 | Манай газраас санаачлан аймгийн ЗДТГазарт ажиллаж буй албан хаагчдаас судалгаа авсны үндсэн дээр байгууллагын дэргэд “Хүүхдийн өрөө тохижуулах” төсөл боловсруулж, “Хүүхдийг ивээг сан”-д хүргүүлээд байна. Төслийн зорилго нь албан хаагчдын бага насны хүүхдүүдийн чөлөөт цагийг нь зөв боловсон өнгөрүүлэх, үл хайхрах, харах хүнгүйгээс шалтгаалан гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах юм. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Байгууллагын ил тод байдлын хүрээнд вэб сайттай болох. | 2,5 сая | Бэб сайттай болсон эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд umch.du.gov.mn хаяг бүхий вэб сайтыг ажлуулахаар байгууллагын нөөц хөрөнгөд тулгуурлан 2,5 сая төгрөгөөр гэрээ байгуулан хийлгэж байна. | 70 |
| 4 | **Зорилт 4. Цахим системийн ашиглалтыг нэмэгдүүлэх** | | Тендерт оролцогчийн лавлагаа мэдээллийг түргэн шуурхай цахим системээр татсанаар хуурамч материал ирүүлсэн компанийн тоо буурна. | 0 | 0 | 2022 оны 01 сараас Тендерт оролцогчийн өр төлбөртэй эсэх лавлагааг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем болон цахим үйлчилгээний нэгдсэн портал “E-mongolia” системийг ашиглан тендер нээсэн өдрийн байдлаар татсанаар хуурамч лавлагаа мэдээлэл ирүүлэх байдал буураад байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар тендерийн материалыг хуурамчаар үйлдэж сангийн яамны “эрхээ хязгаарлуулсан оролцогчийн бүртгэл” орсон тохиолдол гараагүй байна. | 100 |
| 4.1 | Байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудасны дагагчийн тоог нэмэгдүүлэх | | Нэмэгдсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 2000 | 2100 | Байгууллагын ”Орон нутгийн өмчийн газар” фейсбүүк аккаунтыг тогтмол хөтөлж байгууллагатай холбоотой “Тендерийн урилга”, “Нээлттэй дуудлага худалдааны зар” зэрэг үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр оруулан ажиллаж байна.Дагагч болон найзын тоо 2300-д хүргээд байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  | |
| 4.2 | Тендер шалгаруулалтад оролцогч нэгжүүдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем болон цахим үйлчилгээний нэгдсэн портал “ “E-mongolia” системийг ашиглан шалгах ажлыг аймгийн хэмжээнд нэвтрүүлэх | | Тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг “ХУР” болон “E-mongolia” системээс шалгасан тоо | 255 | 300 | Худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем болон цахим үйлчилгээний нэгдсэн портал “ “E-mongolia” системээс тендерт оролцогчийн “Татварын ерөнхий газарт өр төлбөргүй эсэх лавлагаа”, “Нийгмийн даатгалын ерөнхий газарт өр авлагагүй эсэх лавлагаа”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй эсэх лавлагаа”, “Шүүхийн тусгай архивын газарт сүүлийн 3 жилд хариуцагчаар татагдсан эсэх лавлагаа”, “голлох инженер техникийн ажилчдын сургууль төгссөн эсэх дипломын лавлагаа”, “авто машин тээврийн хэрэгслийн лавлагаа” зэргийг тендер нээсэн өдрийн байдлаар татдаг болсноор 2023 оны жилийн эцсийн байдлаар 695 мэдээлэл лавлагааг татаад байна. | 100 |
| 4.3 | Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлэх | | системээс нэвтрүүлсэн эсэх Тийм-1 Үгүй-0 | 0 | 1 | Хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн системийг нэвтрүүлж эхлээгүй байна. | 0 |

| 5.Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1 | Төрийн байгууллага бүр албан хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг турших | | хэрэгжилтийн тайланг БШУГ-т хүргүүлэх тоо / сар бүр/ | 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн | 5 | Байгууллагын албан хаагчдын дунд Монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдаж байгаатай холбогдуулан Д.Пүрэвдоржийн “Тусгаар тогтнол” шүлгийг монгол бичгээр цэвэр сайхан бичих “Би цэвэр бичигтэн” уралдааныг зохион байгуулж Өмч хариуцсан мэргэжилтэн Б.Үүрийнтуяа цэвэр нямбай бичиж тэргүүллээ. Мөн аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хос албан бичгээр бичсэн тоотын хамт хэрэжүүлсэн ажлын талаархи тайланг хүргүүлээд байна. | 100 |
| | | | Туршсан эсэх тийм -1, үгүй -0 | 0 | 1 | Боловсрол, шинжлэх ухааны газарт хос албан бичгээр бичсэн тоотын хамт хэрэгжүүлсэн ажлын талаарх тайланг хүргүүлээд байна. | 100 |
| 5.2 | Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг төрийн албаны мэрэгшүүлэх багц сургалтад хамруулах | | Сургалтад хамрагдсан албан хаагчдын хамрагдалтын хувь өссөн байна | 0 | 1 | Газрын дарга Б.Адъяасүрэн, өмчийн мэргэжилтэн Б.Үүрийнтуяа, Б.Номингэрэл нар тарийн албан хаагчдыг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад, Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Б.Сайхантуяа Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг төрийн албаны мэрэгшүүлэх багц сургалтад хамрагдаад байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.3 | Албан хаагчдад үндэсний бичгийн дунд шатны сургалтыг зохион байгуулж, батламж гардуулна. | 360 мянга | Дунд шатны модуль сургалтад хамрагдаж батламжаа гардан авсан албан хаагчдын хувь | 0 | 100 | 2025 оноос төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх болсонтой холбогдуулан төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг дээшлүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх, албан бичиг баримтыг үндэсний бичгээр хөтлөх, мэдлэг чадварт суралцах ажлын хүрээнд монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдаж гэрчилгээг аваад байна. | 100 |
| | Зорилтын дундаж хувь 4 | | | | | | 100 |
| | Арга хэмжээнүүдийн хувь 18*100 1*95  70*1 30*1 1*0 | | | | | | 90.6 |
| | Үнэлгээний дундаж хувь | | | | | | 95.3 |